

**БАТЛАВ:**  
Монголын хөдөө аж ахуйн  
хоршоологчдын үндэсний холбооны  
Дэд ерөнхийлөгч  Д.Алтантуяа



**БАТЛАВ:**  
Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал  Х.Баатар



## АЖЛЫН БАЙРНЫ ЗОРИУЛАЛТААР ӨРӨӨ ТҮРЭЭСЛЭХ ГЭРЭЭ

№ ТГ-20/02

2020 оны 02 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

**НЭГ ТАЛААС:** Монголын Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Үндэсний Холбоо /цаашид Түрээслүүлэгч гэх/, түүнийг төлөөлж тус холбооны Санхүү аж ахуйн нярав Т.Гэрэлмаа

**НӨГӨӨ ТАЛААС:** “ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ХХК /цаашид Түрээслэгч гэх/-ыг төлөөлж Ерөнхий нягтлан бодогч ажилтай Дансран овогтой Батцэцэг нар Монгол улсын иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Нийтлэг заалт

1.1 Түрээслүүлэгч нь Түрээслэгч байгууллагын хүсэлтийг харгалзан өөрийн эзэмшлийн байранд 201-211, 106 тоот өрөөг албан ажлын өрөөний зориулалтаар түрээслүүлэх, Түрээслэгч нь түрээсийн гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэн биелүүлэх, түрээсийн төлбөр бусад холбогдох тооцоог хугацаанд хийх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

### Хоёр. Гэрээний үнэ

2.1 Түрээсийн талбайн нэг м2-ийн хөлс сард **25,000 /Хорин таван мянган/** төгрөг ба нийт **391м2** талбайн хөлс **9,775,000 /Есөн сая долоон зуун далан таван мянган/** төгрөг байна.

2.2 Түрээслэгч ажлын өрөөг хүлээн авч түрээсийн төлбөр болох нийт **9,775,000 /Есөн сая долоон зуун далан таван мянган/** төгрөгийг **сар бүрийн 10-ны** дотор төлөх үүрэгтэй.

2.3 Түрээсийн төлбөрийг бэлэн бусаар хийнэ.

2.4 Түрээслэгч нь түрээсийн төлбөрийг энэхүү гэрээний 2.2 дүгээр зүйлд заасан хугацаанаас хожимдуулан төлөх нөхцөлд **түрээсийн төлбөрийн нийт дүнгээс хоног тутам 0.5 хувиар тооцсон алдангийг түрээсийн төлбөр дээр нэмж төлөх үүрэг хүлээнэ.**

2.5 Жилд 2 удаа (эхний хагас жил болон жилийн эцэст) түрээсийн төлбөрийн тооцоог нийлж, жилийн эцэст гэрээний биелэлтийг дүгнэнэ.

